| 3.1.2.1 | Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил үйлчилгээ, худалдан авах ажиллагааг иргэд, олон нийтэд ил тод, нээлттэй болгож тендерийн урилга, үр дүнгийн мэдээллийг улс,аймгийн сумын вэбсайт болон пейж хуудсаар тухай бүр мэдээлнэ. | ОНТ | Нийтэлсэн тендрийн эзлэх хувь | 2021 | 100 | 100 | Шилжих хөрөнгөөр 1, Малын тоо толгойн албан татварын хөрөнгөөр санхүүжигдэх, 2022 оны ОНХС-ын хөрөнгөөр шинээр хийгдэх 18 төсөл хөтөлбөр арга хэмжээ төлөвлөснөөс хагас жилийн төсвийн тодотголоор 1 ажил хасагдаж тайлант оны жилийн эцсийн байдлаар шилжих хөрөнгө оруулалтын 1, шинээр эхлэх 4 төсөл хөтөлбөр арга хэмжээг хуулийн дагуу цахимаар зарлаж, 10 хөтөлбөр төсөл арга хэмжээг шууд худалдан авах аргаар гэрээ байгуулах эрх олгож гэрээ байгуулан үр дүн болон бүх гэрээг системд 100% оруулан нийтэлсэн. | 100 |
| 3.1.2.2 | Төрийн худалдан авах ажиллагааг зохион байгуулах А3-н сургалтанд иргэдийг хамруулж гэрчилгээжүүлэх, үнэлгээний хорооны гишүүдийг чадавхижуулна | ОНТ, иргэд | А3 сертификат эзэмшигчийн иргэдийн тоо | 2021 | 10 | 15 | 2021 оны 04 сард 7 иргэнийг, 11 сард 6 иргэнийг суралцуулж нийт 13 хүн суралцанаас 10 иргэн тэнцэж А3 сертификат эзэмшсэн байгаа бөгөөд 2022 оны 10 сард дахин 5 хүнийг сургалтад хамруулан 5 хүн тэнцэж нийт 15 иргэнтэйгээр цахим худалдан авах ажиллагааг зохион байгуулж байна. | 100 |
| 3.1.2.3 | Төсөв санхүүгийн ил тод байдлыг хуулийн хүрээнд болон бусад хэлбэрээр зохион | | Мэдээлсэн ажил үйлчилгээ, худалдан авалтын | 2021 | 5 | 6 | Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлийн хүрээнд ТЕЗахирагч болон түүний харьяа төсвийн байгууллагууд нь нийт | **100** |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | байгуулж олон нийтэд мэдээлж ажиллана. | | тоо | | | | 1230 ширхэг мэдээллийг байршуулахаас одоогоор хуулийн хугацаа нь болсон 1087 ширхэг мэдээллийг хугацаанд нь мэдээлсэн. Мөн ТЕЗахирагч болон төсөвт байгууллагуудын ил тод байдлын мэдээллийн самбарт цаасан хэлбэрээр байршуулахаас гадна dundgovi.gov.mn сайтад сарын бүрийн ТЕЗахирагчийн мэдээ, Батлагдсан төсөв, Санхүүгийн тайлан, Аудитын байгууллагын дүгнэлт зэргийг байршуулсан. | |
| **3.2 Уул уурхай, хүнд үйлдвэр** | | | | | | | | |
| **Зорилго: Лицензтэй аж ахуйн нэгжүүдийг хуулийн хүрээнд ажиллуулах, шинээр лиценз олгуулахгүй байх** | | | | | | | | |
| Зорилт 3.2.1 | Хяналт шалгалтыг тогтмол зохион байгуулна. | Тухайн жилийн төсөв - 0.8 | 10 удаа зохион байгуулах | 2021 | 2 | 3 | Байгаль орчны менежментийн төлөвлөгөөнд 3 удаагийн хяналт шалгалтыг зохион байгуулсан. Төгрөг, Найз багийн заагт хайгуулийн үйл ажиллагаа явуулахаар ирсэн Петровисресурс ХХК-той холбоотой иргэдийн гомдол мэдээлэлийн дагуу 2 удаа бичиг баримтын болон төлөвлөгөөний хэрэгжилтийн дагуу 2 удаа, гүйцэтгэлийн хяналт шалгалтыг 1 удаа нийт 5 удаагийн шалгалтыг газар дээр нь зохион байгуулж ажилласан. 6 зөрчил дутагдлыг арилгуулахаар улсын байцаагчийн дутагдал арилгуулах тухай албан шаардлагыг хүргүүлж гүйцэтгэлийг шалгаж ажилласан. | **100** |
| 3.2.1.1 | Ашигт малтмалын лиценз эзэмшигчдийн үйл ажиллагаанд | төсөв шаардаг | Хяналт шалгалтын үнэлгээний хувиар | 2021 | 100 | 100 | Түгээмэл тархацтай ашигт малтмалын лиценз эзэмшигч Пүрэвбатхишиг ХХК, Гранд флюрит | 100 |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | нутгийн захиргааны болон хууль тогтоомжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллана. | дахгүй | | | | | ХХК, Алтан тоонот ХХК-ны ирүүлсэн Байгаль орчны менежментийн төлөвлөгөөг хянаж хууль тогтоомжийн хүрээнд шаардлага хангаагүй төлөвлөгөөгнүүдийг буцаан, албан бичгээр зөвлөмж өгсөн. Төгрөг, Найз багийн заагт хайгуулийн үйл ажиллагаа явуулахаар ирсэн Петровисресурс ХХК-той холбоотой иргэдийн гомдол мэдээлэлийн дагуу 2 удаа бичиг баримтын болон төлөвлөгөөний хэрэгжилтийн дагуу 2 удаа, гүйцэтгэлийн хяналт шалгалтыг 1 удаа нийт 5 удаагийн шалгалтыг газар дээр нь зохион байгуулж ажилласан. 6 зөрчил дутагдлыг арилгуулахаар улсын байцаагчийн дутагдал арилгуулах тухай албан шаардлагыг хүргүүлж гүйцэтгэлийг шалгаж ажилласан. | |
| | | | | | | | | |
| | | | | | | | | |
| **Зорилго: Эдийн засаг бизнесийн таатай орчинг бүрдүүлэх, мал аж ахуй, газар тариалан, жижиг дунд үйлдвэр эрхлэгчдийн тогтвортой хөгжлийг хангах** | | | | | | | | |
| Зорилт 3.3.1 | Баялаг бүтээгчдийг дэмжих төсөл арга хэмжээ боловсруулж ажиллана. | 176.5 | Арга хэмжээний хэрэгжилтийн хувиар | 2021 | 50 | 60 | Баялаг бүтээгчдийг дэмжих төсөл арга хэмжээний хүрээнд 2022 онд хог ангилан ялгах, дахин боловсруулах ажлыг эрчимжүүлэхээр иргэдийн бүлэглэлийг дэмжин ажиллаж байна. Мөн мал нядалгааны цех, оёдолын үйлчилгээ эрхлэгчдийг хоршоо рөгжүүлэх сангийн санхүүжилтээр дэмжин ажиллаж | **100** |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | байна. | |
| 3.3.1.1 | “Онги-Чацаргана” брэндийг бий болгоно | 16.5 | 2000 мод тарисан байх | 2021 | 200 | 600 | Өрх бүр чацаргана тариалах уриалга гаргаснаар чацаргана төгөлтэй айл өрхүүд шинээр 150 чацаргана тариалсан. | **60** |
| 3.3.1.2 | “Сайхан-Овоогийн - Мах” брэндийг бий болгоно | 100.0 | Мах нядалгааны төвлөрсөн цэг, агуулахтай болсон байх Мах борлуулах цэгтэй болсон байх | 2020 | 0 | 3 | Сумын хэмжээнд мал нядалгааны нэг цехтэй болохоор төлөвлөсний дагуу хоршоо хөгжүүлэх сангаас Их Бадрах Хайрхан хоршооны мал нядалгааны цех байгуулах төслийг төсөл сонгон шалгаруулах зөвлөлөөр хэлэлцүүлж санхүүжилтийг олгож цехийн барилга байгууламж баригдаж дуусан үйл ажиллагаа эхэлсэн. | **100** |
| 3.3.1.3 | Жижиг дунд үйлдвэр эрхлэгчдийг дэмжинэ | 60.0 | 8 төсөл хөтөлбөр дэмжсэн байх | 2021 | 0 | 3 | Жижиг дунд үйлдвэр эрхлэгчдийг дэмжих ажлын хүрээнд хоршоо хөгжүүлэх сангаас 1 хоршооны мал нчдалгааны цех байгуулах төсөлд 50,000,000, Хог ангилан ялгах төсөлд 15,000,000, оёдолын төсөлд 27,300,000 санхүүжилтыг олгосон. Ахмадын хөдлмөр эрхлэлтийг дэмжих төсөл хөтөлбөрт Мужаан 5,000,000 , хүнсний ногоо тариалалт 5,000,000 , малчдын хөдөлмөр эрхлэлтийг дэмжих малжуулах төсөл хөтөлбөрт 2 өрхийг тус бүр 5,000,000 төгрөгийн санхүүжилт авахад дэмжлэг үзүүлэн хамтран ажиллалаа. | **100** |
| Зорилт 3.3.2 | Чинээлэг малчин төсөл арга хэмжээг хэрэгжүүлнэ | | Төсөл арга хэмжээний хэрэгжилтийн хувиар | 2021 | 10 | 20 | Төлөвлөгөөг боловсруулан малчидруу чиглэсэн сургалт арга хэмжээг зохион байгуулан ажиллаж байна. Эко бүтээгдэхүүн үйлдвэрлэл, хэрэглээ, малын эмийн зохистой хэрэглээ, анхан шатны хоршоо байгуулах хамтран | **100** |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | ажиллахын ач тус зэрэг сургалтыг мэргэжлийн сургагч багштай хамтран зохион байгуулсан. | |
| 3.3.2.1 | Нэг малаас авах ашиг шимийн хэмжээг нэмэгдүүлэх | | Сайжирсан малын тоо | 2021 | 0 | 20 | Судалгааны шатанд явагдаж байна. | 10 |
| 3.3.2.2 | Сумын хэмжээнд үхэр сүргийн тоо, ашиг шимийг нэмэгдүүлэх | | Тоо толгой, ашиг шим нэмэгдсэн байна. | 2021 | | Судалгаа хийгдэнэ | Мах сүүний чиглэлийн хээлтүүлэгчийг худалдан авах 1 судалгаа хийгдсэн. Шаардагдах санхүүжилтийг 2022 оны малын хөлийн албан татвараас санхүүжилтыг тусгуулах саналыг ИТХ-д танилцуулах байсан боловч малын хөлийн албан татварын бүрдэлт муугаас төсөвт суугдаагүй. 2023 оны төсөвт суулгах төлөвлөгөөтэй байна. | **100** |
| 3.3.2.3 | Стандартын шаардлага хангасан цөм сүргийн ангийн хээлтэгч, хээлтүүлэгчийг ээмэгжүүлэн бүртгэж, мэдээллийн нэгдсэн санд хамруулах | 30.0 | Ээмэгжүүлж бүртгэсэн малын тоо | 2021 | 10.0 | 29.6 | Хэрэгжээгүй. | **0** |
| Зорилт 3.3.3 | Бэлчээрийн даац хэтрэлтийг үе шаттайгаар бууруулж, нөхөн сэргээх талбайн хэмжээг нэмэгдүүлнэ. | | Бэлчээр ашиглалтын хувиар | 2021 | | | Цаг агаарын нөхцөл байдал, отор нүүдэл ихэссэнтэй холбогдуулан малын бэлчээрийн даац 3 дахин хэтрэлттэй байна. Бэлчээрийн даац хэтрэлтийг үе шаттайгаар бууруулах, нөхөн сэргээх ажил судалгааны шатанд явагдаж байна. | 30 |
| 3.3.3.1 | Малын тэжээлийн ургамлыг 20- | 5 | Тариалсан талбайн | 2021 | 0 | 5 | энэ онд 1 га талбайд овьёос болон тэжээлийн олон наст ургамлын | **30** |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | н га талбайд тариална. | | өсөлт | | | | тариалалт хийгдсэн байна. | |
| 3.3.3.2 | Айл өрхүүдийг өвөлжөө, хаваржааны дэргэд нөөц бэлчээртэй болгох зорилгоор хашиж хамгаалах, талбайн хэмжээг нэмэгдүүлнэ. | 4.0 | Хашсан бэлчээрийн талбайн өсөлт | 2021 | 0 | 2 | 5 өрх айл өвөлжөө, хаваржааны дэргэд 2 га талбайг нөөц бэлчээр болгон хашсан. | **100** |
| 3.3.3.3 | Бэлчээрийн хортон мэрэгч амьтан, шавьжтай байгаль орчин, хүн, малд халгүй технологи ашиглан тэмцэх ажлыг зохион байгуулна. | 8 | Тэмцсэн талбайн хэмжээ | 2021 | 6 | 5 | 2022 оны Засаг даргын А/20 захирамжаар ажлын хэсэг томилж төрийн албан хаагч, малчин, 6 иргэнтэй гэрээ байгуулан 5000 га талбайд микробиологийн аргаар хортон мэрэгчтэй тэмцсэн. | 100 |
| 3.3.3.4 | Малын бэлчээрийн талбайг гүн өрмийн худаг болон энгийн уурхайн худгаар усжуулна | 15 | Тухайн жилд шинээр гаргах худгийн тоо | 2021 | 1 | 1 | ЗЗБУХТөслөөс Төгрөг багийн Дуган ус, Хашаатын ус, найз багийн Бэлгэхийн худаг, Булгийн худаг, мааньт багийн Босгын худаг, Тэсгэтийн худаг, онги багийн Хажуугийн ус гэсэн 8 ширхэг энгийн уурхайн худгийг засварласан. | **100** |
| 3.3.3.5 | Энгийн уурхайн худгыг засварлах | 5.6 | Засварласан худгын тоо | 2021 | 8 | 7 | Энгийн уурхайн худгийг жилийн эцсээс өмнө засварлахаар 8 сая төгрөгийг төсөвлөөд байна. | **30** |
| Зорилт 3.3.4 | Мал, амьтны халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх тарилгыг графикт хугацаанд нь бүрэн хамруулна | Улсын төсөв ОНтөсөв | Хамрагдсан малын тоо | 2021 | 17200 | 18000 | Мал, амьтны халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх Шөвөг яр, Шүлхий, Дотрын халдварт хордлого, Сахуу мал угаалгын арга хэмжээг зохион байгуулан ажилласан. Төлөвлөгөөт дотрын халдварт хордлогоос урьдчилан сэргийлэх вакцинд Мааньт Онги багийн 15000 мал, галзуу өвчний дархлаажуулалтанд 1100 үхэр, | 100 |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | дуутын дархлаажуулалтанд 598 үхэр, шүлхийн дархлаажуулалтад 5211 үхэр, сахуугийн дархлаажуулалтад 499 унага, шөвөг ярын дархлаажуулалтад 9000 ишиг, бруцеллёз өвчнөөс урьдчилан сэргийлэх дархлаажуулалтад 31000 хурга ишиг, 420 тугал тус тус графикт хугацаанд бүрэн хамрагдлаа. Нийт 62822 толгой мал хамрагдсан. | |
| 3.3.4.2 | Мал угаалгын ажлыг суурин ваннд жил бүр зохион байгуулна | Малчид | Хамрагдсан малын тоо | 2021 | 78000 | 80000 | Мал угаалгын ажил 7,8 саруудад 4 суурин ваннд 45168 хонь, ямаа хамрагдаад байна. | 50 |
| 3.3.4.3 | Орон нутагт үйл ажиллагаа явуулж буй хувийн мал эмнэлэгийн үйл ажиллагааг дэмжиж хамтран ажиллана. | Улсын төсөв , ААН байгууллага | Гэрээний хэрэгжилтийн хувь | 2021 | 90 | 90 | Онги таван-Эрдэнэ ХХК төлөвлөгөөт 7 төрлийн вакцинжуулалтыг график хугацаанд 100% хийж гүйцэтгэсэн. Төлөвлөгөөт бус шаардлагаар 30211 малд дархлаажуулалт хийж гэрээний хэрэгжилтээ 100% хэрэгжүүлсэн. | **100** |
| **3.4 Аялал жуулчлал** | | | | | | | | |
| **Зорилго:Байгальд ээлтэй тогтвортой аялал жуулчлалыг хөгжүүлж жуулчдын тоог нэмэгдүүлэх** | | | | | | | | |
| Зорилт 3.4.1 | Жуулчдад үзүүлэх уламжлалт зан заншил, нутгийн онцлогтой эвент арга хэмжээ зохион байгуулна | 1.5 | Эвент арга хэмжээг 2 болгох | 2020 | 0 | 1 | Хугацаа болоогүй. | |
| 3.4.1.1 | Олон улсын аялал жуулчлалын үзэсгэлэнд жил бүр нэгдсэн зохион байгуулалттай оролцож, | 0.5 | ITM аялал жуулчлалын үзэсгэлэнд | 2020 | 0 | 100 | ITM аялал жуулчлалын үзэсгэлэнд Онгийн нууц, Онги энергийн төв, Сайхан-Говь жуулчны баазууд | **100** |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | орон нутгаа сурталчилна | | жуулчны баазуудыг 100 хувь хамруулах | | | | оролцож үйл ажиллагаагаа таниулан сурталчилж ITM арга хэмжээнд оролцсон. | |
| 3.4.1.2 | Нүүдэлчдийн ахуй онцлогийг харуулсан аялал жуулчлалын “Нүүдэлчин-Малчин” аялалын маршрутыг боловсруулан хэрэгжүүлж, хамрагдах малчин өрхийн тоог нэмэгдүүлнэ | 1.0 | Маршрутын дагуу хамрагдах малчин өрхийн тоо нэмэгдсэн байх | 2020 | 0 | 12 | Хугацаа болоогүй. | |
| 3.4.1.3 | Аймгийн тусгай хамгаалалттай Онгийн хийд орчмын байгалийн унаган төрхийг хадгалах, хамгаалах, ашиглах төсөл арга хэмжээг хэрэгжүүлнэ. | 0.5 | Төсөл арга хэмжээг зохин байгуулсан тоо | 2020 | 0 | 1 | Хугацаа болоогүй. | |
| 3.4.1.5 | Аялал жуулчлалын газруудын үйлчилгээний стандартын хэрэгжилтийн дундаж үнэлгээг 90 хувьд хүргэнэ | | үйлчилгээний стандартын хувь | 2020 | 0 | 60 | Жуулчны баазуудын үйлчилгээ стандартын дагуу зохион байгуулагдаж санал гомдол гараагүй. | **100** |
| **3.5 Эрчим хүч** | | | | | | | | |
| **Зорилго: Найдвартай, орчин үеийн эрчим хүчний үйлчилгээгээр иргэдийг хангах.** | | | | | | | | |
| Зорилт 3.5.1 | Сумын төвийн эрчим хүчний найдвартай ажиллагааг хангаж хяналт тавьж ажиллана | хөрөнгө шаардагд ахгүй | Хяналт тавьсан шалгалтын тоо | 2021 | 4 | 4 | Хяналт шалгалтыг:<br>-4,6-р сард Өвөрхангайн эрчим 2 удаа<br>-6-р сард ЭБЦТСК-ийн Өвөрхангай салбарын ашиглалтын инженерээр ахлуулсан баг болон,сумын Засаг даргын захирамжаар томилогдсон хяналтын зөвлөл хамтран эрчим хүчний хүчдэлийн уналтад хяналт тавин баруун лагерыг 15 кВт-ын | **100** |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | шугамаас хуурай салгуур бүхий бетон тулгуураар 100м салбарлуулж 250кВа-ийн АТП дэд станцыг байгуулан өгснөөр сумын төвийн баруун лагерын тогны хэрэглээг сайжруулсан. | |
| 3.5.1.1 | Сумын төвийн 0,4кв-ын шугамыг ЭБЦТСүлжээ ТӨХК-д шилжүүлнэ | | Ажлын гүйцэтгэлийн хувь | 2022 | 0 | 100 | Хяналтын зөвлөл хуралдаж сумын засаг даргын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрт тусгагдсаны дагуу сумын төвийн дотоод хэрэглээний 0,4 болон 0,22-ын бетонон хөлтэй модон тулгуур бүхий эрчим хүчний 8000 гаруй метр шугамыг аймгийн орон нутгийн өмчин газраар уламжлуулан аймгийн ИТХ-аар хэлэлцүүлэн шийдвэрлүүлж Монгол улсын өмчийн бодлого зохицуулалтын хороонд хүргүүлэн ЭБЦТСТӨК-ний Өвөрхангай салбарын үндсэн хөрөнгөд шилжүүлэх хүсэлтийг хүргүүлэн шийдвэрлүүлж ажилласан. | 100 |
| 3.5.1.2 | Цахилгаан ашиглалтын хяналтын сумын зөвлөлийг байгуулж ажиллана. | хөрөнгө шаардагд ахгүй | Байгуулагдсан зөвлөлийн тоо | 2022 | 0 | 1 | Сумын Засаг даргын захирамжаар зөвлөлийг 7 хүний бүрэлдэхүүнтэй байгуулж жил бүр хяналт тавин ажиллаж байгаа бөгөөд тайлант оны 8 сарын байдлаар хамтарсан хяналт 1,бие даасан хяналтыг 1 удаа тус тус тавин ажилласан байна. | 100 |
| Засаглалын бодлого | | | | | | | | |
| ***4.1 Цахим Монгол- төрийн шуурхай үйлчилгээ*** | | | | | | | | |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| **Зорилго: Төрийн үйлчилгээг ил тод,шуурхай,хүртээмжтэй,цаасгүй,хүнд сурталгүй хүргэж цахим засаглалыг хэрэгжүүлэх** | | | | | | | | |
| Зорилт 4.1.1 | *Дижитал шилжилт хийх замаар төрийн байгууллага хоорондын болон иргэн, хувийн хэвшлийн цахим мэдээллийн солилцоо, эргэх холбооны чадавхийг нэмэгдүүлнэ.* | *УТ* | *Цахим мэдээллийн солилцоо 80%-д хүрсэн байна* | 2021 | 60 | 70 | Төрийн цахим үйлчилгээний E-mongolia системийг нэвтрүүлж, төрийн байгууллага хоорондын болон иргэн, хувийн хэвшлийн цахим мэдээллийн солилцоог хангах зорилгоор 12 төрлийн үйл ажиллагааг цахимжуулсан хэрэгжилт 70%-д хүрсэн. | **100** |
| 4.1.1.1 | E-Mongolia.mn цахим үйлчилгээг иргэдэд сурталчилж, хамрагдах иргэдийн тоог нэмэгдүүлнэ | УТ | E-Mongolia.mn цахим үйлчилгээ авч байгаа иргэдийн хувь 65%-д хүрсэн байна | 2021 | 20 | 40 | E-Mongolia.mn цахим үйлчилгээний Хур системээр 2022 онд нийт 36 иргэн 5-н төрлийн үйлчилгээг төлбөртэй 26, төлбөргүй 7 авсан. Энэ системийг ЗДТГ-ын архив бичиг хэргийн эрхлэгч хариуцан ажиллаж байна. | **30** |
| 4.1.1.2 | Төрийн байгууллагын дотоод удирдлагын нэгдсэн www.erp.e-mongolia.mn системийг төрийн байгууллагууд бүрэн ашиглаж хэвшүүлнэ. | ОНТ | www.erp.e-mongolia.mn системийг 100% ашигласан байх | 2021 | 100 | 100 | 5 байгууллагын 20 албан хаагч ERP системийг бүрэн ашиглаж байна. Байгууллагын удирдлагууд албан хаагч нартаа системээр үүрэг даалгавар өгч, үүрэг даалгаврын үйл ажиллагааг цахимаар хянан ажиллаж байна. | **100** |
| 4.1.1.3 | Архивын баримтын 95-аас доошгүй хувийг цахим хэлбэрт шилжүүлж, иргэдэд архивын үйлчилгээг цахимаар үзүүлэх нөхцлийг бүрдүүлнэ | УТ | Цахим хэлбэрт шилжүүлсэн баримтын хувь | 2021 | 91 | 92 | 2013-2020 онуудын 4 багийн байнга хадгалагдах мал тооллогын А данс захирамжлалын баримт бичгүүдийг цахимд шилжүүлсэн. Нийт 13,279 хуудас хадгаламжийн нэгжийг цахим санд оруулж 92% хэрэгжүүлсэн. | **100** |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| 4.1.1.4 | Архивт нягтруулсан шүүгээ 1-г авч бусад техник хэрэгсэл, тоног төхөөрөмжөөр хангаж, архивын баримт бичгийн хадгалалт, хамгаалалтыг сайжруулна | УТ | тоног төхөөрөмжийн хангалтын хувь | 2021 | 70 | 100 | Шаардлагатай тоног төхөөрөмж, хэрэгслээр 100% хангагдан ажиллаж байна. | 100 |
| 4.2 Мэргэшсэн, хариуцлагатай төрийн алба | | | | | | | | |
| **Зорилго: Хуулийг чандлан баримтлаж, авилга, ашиг сонирхолоос ангид, ил тод нээлттэй түргэн шуурхай ажиллах** | | | | | | | | |
| Зорилт 4.2.1 | Төрийн албаны стандартыг мөрдөж, төрийн байгууллага, төрийн албан хаагчийн үйл ажиллагааг тасралтгүй зохион байгуулна. | | томилгооны зөрчлийн бууралтын хувь | 2021 | 1 | 1 | Ажлын байрны ерөнхий болон тусгай шаардлагыг хангасан , тухайн албан тушаалын сонгон шалгаруулалтанд тэнцсэн 2-н албан хаагчдыг сумын эрүүл мэндийн төвийн их эмчээр томилж сул орон тоог хуулийн дагуу нөхөн ажилласан. | 100 |
| 4.2.1.1 | Улс төрөөс хараат бус, чадахуйн зарчим, шатлан дэвших тогтолцоонд нийцсэн мэргэшсэн тогтвортой төрийн албыг бэхжүүлнэ | | Шатлан дэвшсэн төрийн албан хаагчдын хувь | 2021 | 3 | 4 | 2022 онд ТАХ-с дэвшин ажилласан төрийн албан хаагч байхгүй байна. | **100** |
| 4.2.1.2 | Иргэнийг төрийн албан тушаалд томилсны дараа богино болон дунд хугацааны сургалтад орон зай, цаг хугацаанаас үл хамааран бүрэн хамруулна | | Богино болон дунд хугацааны сургалтад хамрагдсан албан хаагчдын тоо | 2021 | 8 | 8 | Орон нутагт дотоодын сургалтуудыг төсвийн байгууллагууд зохион байгуулсан.<br><br>Үүнд: 1. Байгууллагын гүйцэтгэлийн төлөвлөгөө боловсруулах сургалтыг 3-р сард нийт -4 албан хаагчдад | **100** |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | 2. Албан хэрэг хөтлөлтийн стандартын сургалтыг 5-р сард 28-н албан хаагчдад<br><br>3. Аймгийн ХШҮ-ний багаас зохион байгуулсан онлайн сургалтанд 26 албан хаагч хамрагдсан.<br><br>68 албан хаагчийг 84 удаагийн сургалтад хамруулсан | |
| 4.2.1.3 | Бүх шатанд шийдвэр боловсруулах, батлах, хэрэгжүүлэхдээ иргэд, иргэний нийгмийн байгууллага, хувийн хэвшилийн саналыг сонсох, тусгах, зөвлөлдөх, хяналт тавих нөхцлийг бүрдүүлж, оролцоог нэмэгдүүлнэ | | Батлагдсан захиргааны хэм хэмжээ тогтоосон эрх зүйн актыг Улсын нэгдсэн санд бүртгүүлсэн хувь | 2021 | 100 | 100 | 2021 онд Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2021 оны 12 дугаар сарын 16-ны өдрийн “Малын тоо толгойн албан татварын хэмжээнд өөрчлөлт оруулах тухай” захиргааны хэм хэмжээ тогтоосон эрх зүйн акт буюу 24 дүгээр тогтоолыг 2022 оны 01 дүгээр сарын 04-ны өдөр Захиргааны хэм хэмжээний актын улсын нэгдсэн санд хүлээн авч 5040 дугаарт бүртгүүлсэн.<br>Мөн тус хурлаас гарсан “Малын тоо толгойд 2022 онд ноогдуулах албан татварын хэмжээ тогтоох тухай” 25 дугаар тогтоолыг Захиргааны ерөнхий хуулийн дагуу хянан үзээд захиргааны хэм хэмжээний актын улсын нэгдсэн бүртгэлийн 5625 дугаарт бүртгүүлсэн байна.<br>өөрчлөгдөөгүй | **100** |
| 4.2.1.4 | Авлига, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх үйл ажиллагаанд иргэд, олон | | Шударга байдлын үнэлгээ | 2021 | 70.5 | 72 | Сайхан-овоо авлигагүй хөгжинө уриалгыг хэрэгжүүлсний үр дүн төрийн байгууллагуудын цахим хуудасны үнэлгээгээр 70,5% | 100 |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | нийтийн оролцоог сайжруулж, шударга байдлын үнэлгээг нэмэгдүүлнэ | | | | | | үнэлэгдсэн. | |
| 4.2.1.5 | Бүх нийтийн эрх зүйн боловсролыг дээшлүүлэх, хүний эрхийг хангахад чиглэсэн хууль зүйн тусламж, үйлчилгээ, сургалт, суртчилгааг жил бүр зохион байгуулна | | Тухайн жилд эрх зүйн сургалт, сурталчилгаанд хамрагдсан иргэдийн хувь | 2021 | 12 | 13 | 2022 онд Иргэдийн эрх зүйн боловсролыг дээшлүүлэх сургалтын хөтөлбөрийг боловсруулж тус хөтөлбөрөөр 34 төрлийн хууль тогтоомжийг иргэд олон нийтэд цахим болон танхимаар сурталчилж ажилласан. Үүнээс :<br>Танхимаар 21 хуулийг 1082 иргэнд сурталчилсан.<br>Цахимаар 13 хуулийг сурталчилсан хандалтын тоо 4156<br>4 хуулийн 152 ш гарын авлага материалыг иргэдэд тараасан. | **100** |
| 4.2.1.6 | Хүний эрхийг хамгаалах төр, иргэний байгууллагын хамтын ажиллагааг бэхжүүлж, төлбөрийн чадваргүй иргэдэд үнэ төлбөргүй хууль зүйн туслалцаа, үйлчилгээ үзүүлнэ | | Тухайн жилд үнэ төлбөргүй өмгөөллийн үйлчилгээ авсан иргэний тоо | 2021 | 5 | 6 | Дундговь аймагт төлбөргүй өмгөөллийн үйлчилгээ үзүүлдэг хуульч Чимэддуламтай 7 иргэнийг холбон өгч өмгөөллийн үйлчилгээг үзүүлсэн. | 100 |
| 4.2.1.7 | Жендерийн мэдрэмжтэй төсөвлөлт сургалтыг зохион байгуулна | | Сургалтанд хамрагдсан удирдлага, албан хаагчдын тоо | 2021 | 5 | 6 | 6-р сард merit төслийн хүрээнд зохион байгуулсан сургалтанд ЗДТГ-ын дарга хамрагдсан. | 100 |
| 4.2.1.8 | Орон нутагт шаардлагатай боловсон хүчний нөөц бүрдүүлэн томилгооны | | томилгооны зөрчлийн | 2021 | 100 | 100 | Томилгооны зөрчил 2022 оны 8-р сарын байдлаар байхгүй | 100 |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | зөрчилгүй ажиллана | | бууралтын хувь | | | | | |
| **4.3 Хүний эрхийг дээдэлсэн амар тайван, аюулгүй нийгэм** | | | | | | | | |
| **Зорилго: Сумын иргэд аюулгүй орчинд сэтгэл хангалуун ажиллаж амьдрах орчныг бүрдүүлэх** | | | | | | | | |
| Зорилт 4.3.1 | Орон нутгийн иргэдийн амар тайван, аюулгүй байдлыг хангана | УТ ОНТ 4.5 | Бүртгэгдсэн гэмт хэргийн тоо | 2021 | 2 | 1 | 2022 онд 2 гэмт хэрэг гарсан. 2022 оноос гэмт хэргийн шийдвэрлэлт 100%. | 50 |
| | | | Гэмт хэргийн шийдвэрлэлтийн хувь | 2021 | 80 | 90 | | |
| 4.3.1.1 | Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх сургалт сурталчилгааг үе шаттай зохион байгуулна. | УТ | Зохион байгуулсан сургалтын тоо | 2021 | 5 | 6 | Хорт зуршил, Архины хэрэглээ, Цахим гэмт хэргээс урьдчилан сэргийлэх тухай, Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хууль, Гэр бүлийн хүчирхийлэл, дарамт шахалт, Хохирогчийн аюулгүй байдлыг хангах журам, Мал хулгайлах гэмт хэрэгтэй тэмцэх, урьдчилан сэргийлэх талаар 6 удаа сургалт зохион байгуулсан. 262 хүн хамрагдсан. | 100 |
| 4.3.1.2 | Мал хулгайлах гэмт хэрэгтэй тэмцэх, урьдчилан сэргийлэх ажиллагаанд иргэдийн сонор сэрэмж, хариуцлагыг нэмэгдүүлнэ. | УТ, ОНТ | Мал хулгайлах гэмт хэргийн бууралт | 2021 | 0 | 0 | 2022 онд малын хулгай бүртгэгдээгүй. | 100 |
| 4.3.1.3 | Гэмт хэргийн улмаас иргэдэд учирсан хохирлыг барагдуулах | иргэд | Хохирол нөхөн төлүүлэлтийн хувь | 2021 | 100 | 100 | 2 гэмт хэргийн хохирлыг 100% барагдуулсан. | **100** |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | хувийг нэмэгдүүлнэ | | | | | | | |
| 4.3.1.4 | Сумын төвийг камержуулна. | СОНХС | камерийн тоо | 2020 | 3 | 5 | Хуучин 3 камер ажиллаж байгаа. 2022 онд шинээр ЕБС-н 14 ширхэг- 6149200 төгрөг , хүүхдийн цэцэрлэг 13 ширхэг- 4489100 төгрөг нийт 27 ш 10638300 төгрөг | **100** |
| 4.3.1.5 | Цагдаагийн албан хэрэгцээнд шаардлагатай техник хэрэгсэл, тоног төхөөрөмжөөр хангана | УТ, ОНТ | хангагдсан төхөөрөмжийн хангалтын хувь | 2020 | 70 | 100 | Цагдаагийн хэсэгт иж бүрэн суудлын жижиг автомашиныг аймгийн цагдаагийн газраас шилжүүлэн авч техник хэрэгслээр бүрэн хангасан. | **100** |
| Зорилт 4.3.2 | Гамшигтай тэмцэх бэлтгэл бэлэн байдлыг хангана. | УТ, ОНТ | Гамшгийн эрсдэлийн бэлэн байдлын хувь | 2021 | 68 | 70 | Гамшигтай тэмцэх бэлтгэл бэлэн байдлыг хангуулах арга хэмжээг шат дараатай хэрэгжүүлэн ажиллаж байна. Ковид, бог малын мялзан өвчинөөс урьдчилан сэргийлэх, шороон шуурга зэрэг гамшигт үзэгдлийн үед хариу арга хэмжээг хэрэгжүүлснээр гамшигтай тэмцэх бэлтгэл бэлэн байдал 100% хангагдаж ажилласан. | **100** |
| 4.3.2.1 | Аюулт үзэгдэл, ослоос урьдчилан сэргийлэх мэдээллийг малчид, иргэдэд шуурхай дамжуулах техникийн бэлэн байдлыг хангана | ОНТ | Утасны эрх сэргээсэн малчидын тоо | 2021 | 2 | 2 | Толгойн сэргийлэгч / цаг уур/ -ын станцын суурин утасны эрхийг 1 жилээр сунгаж өгсөн: Мөн толгойн сэргийлэгч 2-р багийн 1 малчин өрхийн утасны эрхийг 1 жилээр аймгийн онцгой байдлын газраас сунгалт хийлгэсэн. | 100 |
| | | ОНТ | Сэрэмжлүүлэг мэдээ, зөвлөмж дамжуулсан тоо | 2021 | 8 | 10 | Нутаг дэвсгэрт тохиолдсон байгалийн гамшигт үзэгдэл шороон шуургын сэрэмжүүлэх мэдээ мэдээллийг нийт 12 удаа иргэдэд мэдээллэж ажилласан. / СайханОвоо сумын нийт зарын группууд, ЗДТГ-н фээж хаягаар / хандалтын тоо | **100** |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | 2259. 57 удаа бусдад дамжуулж шейр хийсэн. | |
| 4.3.2.2 | Гамшгаас хамгаалах бэлэн байдлын сургалтанд орон нутгийн иргэдийг хамруулна | ОНТ | Сургалтад хамрагдсан хүн амын эзлэх хувь | 2021 | 3 | 4 | Гамшгийн эрсдэлийг бууруулах сургалтыг 05-р сард зохион байгуулсан. Сургалтанд томилгоот нэгжийн 66-н албан хаагчдаас 53 албан хаагч хамрагдсан. | 100 |
| 4.3.2.3 | Гамшигтай тэмцэх чадавхыг нэмэгдүүлж суманд дадлага сургууль үзлэг зохион байгуулна | ОНТ | Дадлага, сургууль зохион байгуулагдсан тоо | 2020 | 0 | 1 | Аймгийн онцгой байдлын газраас гамшгаас хамгаалах тухай хууль тогтоомжийг сурталчлах, хэрэгжилтийг хангуулах орон нутгийн мэргэжлийн анги, ажилтан, ард иргэдийн аюулгүй амьдрах ухааны мэдлэг ойлголтыг дээшлүүлэх, Онцгой байдлын албаны үйл ажиллагааг сурталчлах зорилгоор 2022 оны 05-р сард сумын ерөнхий зориулалтын мэргэжлийн ангийн бүрэлдэхүүнийг чадавхжуулах танимын болон хээрийн дадлага сургалтыг мөн ЕБСургуулийн сурагчид, СӨБ-н байгууллагын сурагчид, багш, ажилчдад аюулгүй амьдрах ухааны мэдлэг олгох сургалтуудыг тус тус зохион байгууллаа. Сургалтанд томилгоот нэгжийн 66-н албан хаагчдаас 53 албан хаагч хамрагдаж гамшгийн эрсдэлийг бууруулах олон талын мэдлэг мэдээллээр мэдлэгээ дээшлүүлсэн | 100 |
| **4.5 Батлан хамгаалах** | | | | | | | | |
| **Зорилго: Орон нутгийн батлан хамгаалах чадавхыг бэхжүүлж, нийгмийн аюулгүй байдлыг хангана.** | | | | | | | | |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| Зорилт 4.5.1 | Орон нутгийн хамгаалалт, дайчилгааны бэлтгэл нөөцийн бүрэлдэхүүний онцгой нөхцөлд үүрэг гүйцэтгэх чадамжийг нэмэгдүүлнэ | ОНТ | Цэргийн дайчилгааны даалгавар, төлөвлөлтийн онол, дадлагын бэлтгэлийн хувь | 2021 | 82 | 84 | 2022 оны цэргийн шинэчилсэн тоо бүртгэлээр 1-р зэргийн бэлтгэл үүрэгтэн 255, 2-р зэргийн бэлтгэл үүрэгтэн 302, бэлтгэл ахлагч 4, бэлтгэл офицер 5, нийт 566 иргэн хамрагдсанаас 1-р зэргийн 24 иргэнийг тодотгон томилгоожуулсан. Мөн 2-р зэргийн бэлтгэл үүрэгтэн 32 иргэнийг ОНХТ-нд тодотгон томилгоожуулсан. | 100 |
| 4.5.1.1 | Ахлах ангийн сурагчдад "Эх оронч" үндэсний хөтөлбөрийг сурталчилан таниулна | ОНТ | Сургалтын хувь | 2021 | 50 | 70 | 10-р сард зохион байгуулхаар төлөвлөгдсөн. | 50 |
| 4.5.1.2 | Орон нутгийн хамгаалалтын томилгоот бүрэлдэхүүний сургалтын тогтолцоог бэхжүүлэх, дайчилгааны төлөвлөлтийг шинэчилэн нөөцийг бүрдүүлнэ | ОНТ | Дайчилгааны бэлэн байдлын нөөцийн хувь | 2021 | 100 | 100 | 2022 онд ОНХТөлөвлөгөөнд тодотгол 100% хийсэн. Бэлэн байдлын нөөцийн хувь 100% | 100 |
| 4.5.1.3 | Дайчилгааны бэлтгэл нөөцийн бүрэлдэхүүний сургалтад иргэдийг хамруулна. | УТ | сургалтанд хамруулсан иргэдийн тоо | 2021 | 1 | 1 | Аймгийн цэргийн штабаас төлөвлөгөөт сургалт хийгдээгүй. | - |
| 4.5.1.4 | Цэргийн албыг биеэр дүйцүүлэн хааж байгаа иргэдийг тухайн жилийн орон нутгийн бүтээн байгуулалтын ажилд оролцуулна | УТ | Бүтээн байгуулалтын ажил оролцсон иргэдийн тоо | 2021 | 5 | 6 | 2022 оны 1-р улиралд 1 иргэн дүйцүүлэх албаар бүрэн хааж тооцоон дуусгасан. 2022 онд шинээр дүйцүүлэх албаар биеэр цэргийн алба хаах хүсэлт өгсөн иргэн байхгүй болно. | **100** |
| Ногоон хөгжлийн бодлого | | | | | | | | |
| **5.1 Ногоон хөгжил** | | | | | | | | |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| **Зорилго: Иргэдийн оролцоог хангаж ногоон амьдралын хэв маягийг төлөвшүүлэх** | | | | | | | | | |
| Зорилт 5.1.1 | Эко сум төсөл арга хэмжээг хэрэгжүүлнэ. | 0.18 | Хэрэгжилтийн хувиар | 2021 | 50 | 70 | Эко сумын төв төлөвлөгөөнд 7 зорилтын 25 арга хэмжээ төлөвлөсөн үүнээс 2022 онд 22 ажил биелэгдсэн.<br>Нийт хөтөлбөрийн хэрэгжилт 88% -тай. | **100** |
| 5.1.1.1 | Экологийн боловролын талаар сургалтыг зохион байгуулна | 0.1 | Сургалтын тоо | 2021 | 4 | 5 | Цахим орчинд 1 удаагийн сургалт 2 даагийн зөвлөмж сэрэмжлүүлэгийг хүргэж 568 удаагийн хандалт авсан. 4 багийн ИНХ-д 80 ширхэг боршур тарааж, 80 хүнд сургалт мэдээлэл хийсэн.<br>Олон нийтийн оролцоотой сумын хог хаягдлын менежментийг сайжруулах нь" "Хог хаягдлыг эх үүсвэр дээр нь ангилан ялгах тухай" 2 өдрийн сургалтыг "Монголын тандан судлаачдын холбоо" ТББ-ын Б.Эрдэнэ багшийг урьж ЕБСургуулийн 264 сурагч болон иргэд олон нийтийн дунд зохион байгуулсан. Хог хаягдлын тухай хууль, Амьтаны тухай хуулийн талаар 47 иргэнд мэдээлэл хийсэн. Усны тухай сургалтыг сургууль цэцэрлэгийн 217 хүүхдэд хийсэн.<br>Нийт иргэд хүүхэд залуучуудад 3 удаагийн сургалтыг давхардсан тоогоор 528 иргэн хийсэн. | **100** |
| 5.1.1.2 | Эко сумын төв төлөвлөгөөг боловсруулж хэрэгжүүлнэ | | Төлөвлөгөөний хэрэгжилтийн хувь | 2021 | 30 | 60 | Эко сумын төв төлөвлөгөөнд 7 зорилтын 25 арга хэмжээ төлөвлөсөн үүнээс 2022 онд 18 ажил биелэгдсэн. Хэрэгжилт 72% байна. | **100** |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| 5.1.1.4 | Сумын нутаг дэвсгэрт ойн зурвас байгуулна | | Ойн зурвас байгуулсан талбайн хэмжээ | 2020 | 0 | 1 | 2022 онд 13200 ширхэг мод бут тариалж ногоон байгууламжийн хэмжээг 7.6 га-аар нэмэгдүүлж цэцэрлэгт хүрээлэн ойн зурвас байгуулсан. нийт 360 иргэн хүүхэд залуучууд мод тарих ажилд хамрагдсан. | **100** |
| Зорилт 5.1.2 | Усны бохирдол, хомсдлоос сэргийлж, шаардлага хангасан ундны эх үүсвэрээр хангагдана | 31.9 | Шаардлага хангасан ундны эх үүсвэрээр хангагдсан хүн амын тоо | 2021 | 126 | | Унд ахуйн стандартын шаардлага хангадаг “Онги 2” худгаас сумын төвийн 183 өрхийн 549 иргэн хангагдаж байна. | **100** |
| 5.2.2.3 | Булгийн эхийг хашиж хамгаалах, тохижуулах ажлыг зохион байгуулна | | Хашсан булгийн тоо | 2020 | 0 | 1 | 3-р багийн нутаг Жарантайн булгийн эхийг хашиж хамгаалахаар Дундговь аймгийн Байгаль орчин аялал жуулчлалын газарын БОНСАХ 5,000,000 (таван сая) төгрөгний зардлаар Иргэн М.Олзбат булгийн эхийг хашиж хамгаалах ажлыг гэрээгээр гүйцэтгэж актаар хүлээлгэн өгч орон нутгийн өмчид шилжүүлсэн. | 100 |
| Зорилт 5.1.3 | Тусгай хамгаалалттай газар нутгийн хэмжээг нэмэгдүүлэх ховор ан амьтныг хамгаалах | 2.5 | Тусгай хамгаалалттай газар нутгийн тоо | 2021 | 1 | 2 | Хугацаа болоогүй. | |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| 5.1.3.1 | Орон нутгийн тусгай хамгаалалттай газар нутгийн хэмжээг нэмэгдүүлэх шийдвэр гаргуулна. | | Ан амьтныг хамгаалсан арга хэмжээний тоо | 2021 | 6 | | Нийт 2 удаа хамгаалах арга хэмжээг авч 100% хэрэгжүүлсэн. | 30 |
| | | | шийдвэрийн тоо | 2020 | 0 | 1 | Хугацаа болоогүй. | |
| 5.1.3.2 | Ахар ууланд буй ховордсон ан амьтныг хамгаалах байгаль орчин, ан амьтдыг хамгаалах иргэдийн нөхөрлөлийг дэмжинэ | БОХ | Дэмжсэн ажлын тоо | 2021 | 1 | 1 | 2022 онд Зэрлэг амьтдын амьдрах орчин нөхцлийг сайжруулж, идэш тэжээлийн хомсдолоос үүссэн зүй бус хоргодлоос сэргийлж, биотехникийн арга хэмжээг 1 удаа зохион байгуулж 225,000 хоёр зуун хорин таван мянга төгрөг зарцуулсан . | **100** |
| Орон нутгийн хөгжлийн бодлого | | | | | | | | |
| **6.1 Бүс, орон нутаг, хөдөөгийн хөгжил** | | | | | | | | |
| **Зорилго : Дэд бүтцийг хөгжүүлэх хүрээнд хэсэгчилсэн болон хөгжлийн ерөнхий төлөвлөгөөг боловсруулан, инженерийн хангамжтай орон сууц болон хувийн сууцыг нэмэгдүүлж, иргэдийн амьдрах нөхцлийг дээшлүүлнэ.** | | | | | | | | |
| Зорилт 6.1.1 | Иргэдийн оролцоотой "Шинэ сум" төсөл арга хэмжээг хэрэгжүүлнэ. | 5.350.0 | хэрэгжилтийн хувиар | 2021 | 20 | 70 | 2022 онд улсын төсвийн хөрөнгөөр хэрэгжүүлэх шинээр 2 арга хэмжээ 5,160,700,000 төсөвт өртгөөр батлагдсан Шинэ сургуулийн барилга, цэвэрлэх байгууламж барих,бохир цэвэрийн шугамд холбох гэсэн төлөвлөгөөний дагуу жилийн эцсийн байдлаар шинэ сургууль,цэвэрлэх байгууламжийн барилга бүрэн баригдаж хүлээлгэн | 100 |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | өгсөн бохирын шугамд холбогдоогүй 75%-ийн ажлыг гүйцэтгээд байна. | |
| 6.1.1.1 | Сумын төвд усан хангамж, ариутгах татуургын шугам сүлжээг бий болгож ашиглалтад оруулна | 1 900,0 | Шугам сүлжээний ажлын гүйцэтгэлийн хувь | 2021 | 50 | 100 | Сумын төвд усан хангамж, ариутгах татуургын шугам сүлжээг бий болгох ажлын зураг төсвийг “Кингсий инженер энд констракшн”ХХК-аар гүйцэтгүүлж хийлгэсэн бөгөөд Цэвэрлэх байгууламжийн барилгын ажлыг Барилга хот байгуулалтын яамнаас 2021 оны 5 сард тендрийг цахимаар зарлаж 2021 оны 06 сарын 16-нд тендрийг нээж 7 сараас ажил эхлэн 2022 оны 12 сарын 12-ний өдөр улсын комисс ажиллан дүгнэлтээр хүлээн авсан байна. 2021онд 1,3 тэр бум төгрөгөөр тендер зарлагдаж гэрээ байгуулсан цэвэр бохир усны шугам ариутгах татуургын шугам сүлжээний ажил 2021 онд ажлаа эхлэн цэвэр усны холболт, цамхагийн ажлуудыг хийж нийт 100%-ийн гүйцэтгэлтэй байна. 2022 онд бохирын шугам татах холбох ёстой боловч хил хаагдсаны улмаас материал олдохгүй байна гэсэн тайлбараар одоог хүртэл тус ажлыг гүйцэтгэгч Эхлэл шинэчлэл прожект ХХК ажлын талбайд ирээгүй байна. | 70 |
| 6.1.1.2 | Сумын төвд 3 км-н хатуу хучилттай авто замын зургийг боловсруулна | 75,900 | мэргэжлийн төсөвчнөөр хийлгэсэн зураг | 2022 | 0 | 1 | Тус оны ОНХС-ын хөрөнгөөр 75,900,000 төгрөг батлагдаж, ажлын даалгаварын дагуу тендрийг хуулийн дагуу зарлан 08 сарын 09-ны өдөр тендрийг нээж үнэлэн Засмал зам ХХК-д гэрээ байгуулах эрх олгох тухай мэдэгдэлийг | 100 |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | хүргүүлэн гэрээ байгуулан ажиллаж зургийг боловсруулж магадлалын дүгнэлтээр оруулан дуусгаж хүлээлгэн өгөөд байна. | |
| 6.1.1.3 | Шинээр баригдах ЕБС-н 320 хүүхдийн хичээлийн барилгыг зураг төсвийн дагуу бариулж ашиглалтанд оруулна. | 1.500.0 | Барилгын гүйцэтгэлийн хувь | 2021 | 50 | 100 | 2021 онд 45% гүйцэтгэлтэй үлдсэн ажил 2022 оны 04 сард барилгын ажил үргэлжлэн эхэлсэн бөгөөд 12 сарын байдлаар 100%-ийн гүйцэтгэлтэйгээр улсын комисст хүлээлгэн өгөөд байна. | 100 |
| 6.1.1.4 | Сумын төвийн хөгжлийн ерөнхий төлөвлөгөөг боловсруулан, батлуулна. | 55,000 | Төлөвлөгөөний хэрэгжилтийн хувь | 2022 | 30 | 100 | Энэхүү ажил нь 2021 оны 10 сард тендер зарлагдаж Арт констакшн ХХК-тай гэрээ байгуулан ажлыг эхлүүлсэн болович ковидын нөхцөл байдлын улмаас удаашран тус онд шилжих хөрөнгө оруулалтаар хийгдэж байгаа бөгөөд 08 сарын байдлаар судалгааны ажил дууссан,суурь дэвсгэр зургууд боловсруулагдаад СИТХ-аар хэлэлцүүлж батлуулан магадлалд өгөхөд бэлэн болоод байна. | 80 |
| 6.1.1.6 | Төгрөг багийн нутагт үүрэн телефоны антен тоног төхөөрөмж суурилуулна. | 90.0 | Харилцаа холбооны сүлжээ сайжирсан өрхийн тоо | 2020 | 0 | 300 | Энэхүү арга хэмжээг хэрэгжүүлэхээр сумын Засаг даргын албан тоотоор үүрэн холбооны оператор компани бүрт хандсан мөн үүргийн санд хандаад байгаа юм.<br>2022 онд УИХ-ын гишүүн Мөнхцэцэгийн санаачилсан Хөдөөгийн хөгжил төслийн хүрээнд улсын төсвийн хөрөнгөөр санхүүжүүлэхээр төлөвлөгдөж байсан болович хэмнэлтийн тухай хуулийн дагуу хасагдаад 2023 онд төсөвт суулган хэрэгжүүлэхээр төлөвлөж байна. | 30 |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| 6.1.1.7 | Соёлын төвийн барилгад их засварыг хийнэ. | 8.0 | Засварын гүйцэтгэлийн хувиар | 2020 | 0 | 4 | Аймгийн ОНХС-ын хөрөнгөөр 2022 онд тус төсөл арга хэмжээг санхүүжүүлэн тендер зарлагдаж Хос соёмбот өргөө ХХК-тай гэрээ байгуулан 2022 оны 07 сарын 15-наас ажил эхлэн 12 сарын 01-ний өдөр хүлээн авах комисс ажиллан хүлээн авсан. | 100 |
| 6.1.1.8 | Сумын төвийн хүүхэд залуучуудын талбайд чийрэгжүүлэлтийн төхөөрөмж суурилуулна. | 80 | төхөөрөмж ашигладаг иргэдийн тоо | 2020 | 0 | 1200 | Сумын ОНХС-ийн хөрөнгөөр 2023 онд хийгдэх арга хэмжээний жагсаалтад тусгаж иргэдээс санал авч эрэмбэлэгдээд зураг төсвийг боловсруулж СИТХ-аар хэлэлцүүлэхээр төлөвлөгдөж байгаа арга хэмжээ юм. | 30 |
| 6.1.1.10 | Иргэдийг зээлийн хөнгөлттэй нөхцөлтэй орон сууцанд амьдрах боломжийг бий болгож 17 айлын орон сууц барина | 450,0 | Барилгын гүйцэтгэлийн хувь | 2021 | 50 | 50 | 17 айлын орон сууцны барилгын зураг төсвийг 2023 оны ОНХС-ийн хөрөнгөөр хийлгэхээр төлөвлөж иргэдээс санал аван эрэмбэлэлгдэж СИТХ-аар батлуулахаар төлөвлөж байна.Барилга барих газрыг сумын төвийн хөгжлийн Ерөнхий төлөвлөгөөнд тусгасан. Нийт 12 өрх захиалга ирүүлсэн. Ипотекийн 6%-ийн зээлд хамрагдах боломжтой барилга юм. Дээрхи ажлууд хийгдсэнээр гүйцэтгэлийн хувь 50 хувьд хүрсэн. | 100 |

ЗДТГазар